



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТУГ-ЫН 2024
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/038/НА-СТА-ОНӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн
захирал: П.Наранцэцэг
Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа	9
3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СНАХ	Санхүү нийцлийн аудитын хэлтэс
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 03. 28 № 01/344
танай _____-ны № _____-Т

"ХОТ ТӨЛӨВЛӨЛТ
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.АМАРТҮВШИН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

НЗД-ын захирамжаар тус ОНӨААТҮГ-ын 2024 оны зорилтот түвшний нийт орлогыг 4,586.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,445.4 сая төгрөгөөр, 141.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь тайлант онд 6,264.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,851.3 сая төгрөгийн зардал гарч, 413.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Орлогын гүйцэтгэл 6,264.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,677.7 сая төгрөг буюу 36.6 хувиар давсан нь нийслэлийн засаг даргын захирамжаар гүйцэтгэсэн нэмэлт ажилтай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь чиг үүргийнхээ дагуу улсын захиалгат ажлуудыг гүйцэтгэж, улс орон нутгийн төсвөөс захиалгат ажлын санхүүжилт авч байгаагаас гадна, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/286 тоот захирамжаар үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд 767.5 сая төгрөгийг баталж, 2024 оны А/1312 тоот захирамжаар 841.8 сая төгрөг болгон тодотгон

баталсны дагуу нийслэлийн төсвөөс 841.8 сая төгрөгийг авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-т заасан аж ахуйн тооцоот газрын "өөрийгөө санхүүжүүлэх зарчим"-тай нийцээгүй, төсвийн хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдаагүй байна.

Бусад асуудал

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгсгөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ	-	-
1.10	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,806,480,088.88	751,477,693.48
1.1.02	Дансны авлага	490,998,615.98	467,053,200.98
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	292,126,062.18	270,906,466.14
1.1.04	Бусад авлага	-	87,586.25
1.1.06	Бараа материал	57,758,205.65	94,812,551.76
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,639,542.04	23,879,393.90
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,654,002,514.73	1,608,216,892.51
1.20	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	288,976,938.41	491,641,786.56
1.2.02	Биет бус хөрөнгө	2,981,800.00	11,548,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	291,958,738.41	503,189,786.56
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,945,961,253.14	2,111,406,679.07
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.10	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	3,551,065,056.00	203,602,044.30
2.1.1.03	Татварын өр	-	1,296,114.80
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	572,727,272.73	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	3,323,473.92
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,123,792,328.73	208,221,633.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.20	Өр төлбөрийн нийт дүн	4,123,792,328.73	208,221,633.02
2.30	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	161,153,013.31	161,153,013.31
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,661,015,911.10	1,742,032,032.74
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	321,056,625.01
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,661,015,911.10	1,420,975,407.73
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,822,168,924.41	1,903,185,046.05
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,945,961,253.14	2,111,406,679.07

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	13,007,510,144.82	6,117,048,891.89
2	Борлуулалтын өртөг	9,876,145,553.70	4,310,617,837.13
3	Нийт ашиг(алдагдал)	3,131,364,591.12	1,806,431,054.76
5	Хүүний орлого	-	130,320,653.95
8	Бусад орлого	11,753,151.69	17,020,000.00
8.1	Орлогын дүн	11,753,151.69	147,340,653.95
9	Борлуулалт, маркетингийн зардал	180,943,172.09	234,801,127.28
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,353,499,038.29	1,031,108,309.13
12	Бусад зардал	94,868,042.06	330,465,409.28
12.1	Зардлын дүн	2,629,310,252.44	1,596,374,845.69
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	565,858.78	(485,369.50)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(181,910.18)
17.1	Олз, гарзын дүн	565,858.78	(667,279.68)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	514,373,349.15	356,729,583.34
19	Орлогын татварын зардал	51,437,335.00	35,672,958.33
20	Татварын дараах ашиг (алдагдал)	462,936,014.15	321,056,625.01
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	462,936,014.15	321,056,625.01

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,273,313,532.43	1,434,466,545.74
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(75,233,635.48)	(75,233,635.48)
3	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	1,198,079,896.95	1,359,232,910.26
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	462,936,014.14	462,936,014.14
9	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,661,015,911.09	1,822,168,924.40
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(115,047,702.37)	(115,047,702.37)
11	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	1,545,968,208.72	1,707,121,222.03
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	321,056,625.01	321,056,625.01
15	Зарласан ногдол ашиг	-	(124,992,801.00)	(124,992,801.00)
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	1,742,032,032.73	1,903,185,046.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	15,080,894,196.27	6,071,536,835.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	14,268,298,161.91	5,024,362,835.03
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,031,653.00	2,184,723.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	610,028,200.00	841,762,900.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	199,536,181.36	203,226,377.41
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,895,685,294.13	9,813,793,016.54
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,456,105,702.92	1,996,261,331.35
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	379,111,233.22	496,323,074.01
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	48,716,527.00	47,322,419.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	33,253,046.00	37,678,380.40
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,889,000.00	5,230,250.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	803,138.07	13,032,065.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,178,428,121.49	297,736,012.24
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	45,056,155.08	53,050,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,739,322,370.35	6,867,159,484.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,193,026,142.13	(3,712,449,778.84)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,753,151.69	130,320,653.95
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	11,753,151.69	130,320,653.95
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	122,446,985.00	317,588,697.75
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	122,446,985.00	306,302,697.75
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	11,286,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(110,693,833.31)	(187,268,043.80)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	874,060.46	-
3.1.4	Бусад	874,060.46	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	40,884,638.68	125,478,170.50
3.2.4	Төлсөн ногдол ашиг	40,881,620.00	124,992,801.00
3.2.5	Бусад	3,018.68	485,369.50
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(40,010,578.22)	(125,478,170.50)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,034,504,490.61	(4,055,002,395.40)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	771,975,598.27	4,806,480,088.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,806,480,088.88	751,477,693.48

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2023 оны гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого - ААН	12,446,773.1	3,888,983.3	5,351,809.9	(1,462,826.6)	137.6
	Борлуулалтын орлого - Төсөв	554,571.1	697,727.3	765,239.0	(67,511.7)	109.7
	Орлогын дүн	13,001,344.2	4,586,710.5	6,117,048.9	(1,530,338.4)	133.4
	Бусад орлого	18,793.2	-	147,340.7	(147,340.7)	-
	Нийт орлого	13,020,137.4	4,586,710.5	6,264,389.5	(1,677,679.0)	136.6
2	Нийт зардал	12,505,764.0	4,429,696.7	5,907,660.0	(1,477,963.2)	133.4
	Үүнээс: Удирдлагын зардал	734,701.9	-	1,031,108.3	(1,031,108.3)	-
3	Татварын өмнөх ашиг, алдагдал	514,373.3	157,013.8	356,729.6	(199,715.8)	227.2
4	Орлогын татвар	51,437.3	15,701.4	35,673.0	(19,971.6)	227.2
5	Цэвэр ашиг (алдагдал)	462,936.0	141,312.4	321,056.6	(179,744.2)	227.2
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	40,881.6	-	124,992.8	(124,992.8)	-
7	Төсөвт төлөх татвар, шимтгэл	1,555,266.6	-	793,557.3	(793,557.3)	-
	НӨАТ	766,543.4	-	42,000.0	(42,000.0)	-
	ААНОАТатвар	250,000.0	-	13,888.1	(13,888.1)	-
	ХХОАТатвар	154,272.0	-	221,678.7	(221,678.7)	-
	ҮХХ албан татвар	3,510.0	-	11,856.8	(11,856.8)	-
	Бусад татвар, төлбөр	1,830.0	-	7,810.7	(7,810.7)	-
	Нийгмийн даатгалын шимтгэл	379,111.2	-	496,323.1	(496,323.1)	-
8	Батлагдсан ажилтны тоо	60.0	81.0	58.0	23.0	71.6
10	Нийт цалингийн сан	1,805,491.2	2,528,736.5	2,533,255.3	(4,518.8)	100.2
11	Нэг ажилтны дундаж цалин	30,091.5	31,219.0	43,676.8	(12,457.8)	139.9
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	1.0	-	100.0
13	Нийт хөрөнгө оруулалт	128,939.4	353,953.4	342,033.7	11,919.7	96.6
14	Нийт авлага	490,998.6	407,241.0	467,053.2	(59,812.2)	114.7
15	Нийт өглөг	4,123,792.3	167,023.7	203,602.0	(36,578.3)	1.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь Нийслэл хотыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх зорилгоор бүс нутгийн хөгжлийн төсөл, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын судалгаа, эрдэм шинжилгээний ажил, барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн зураг төсөл, авто зам гүүрийн зураг төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, зохиогчийн хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг Нийслэлийн Засаг даргын харьяа мэргэжлийн байгууллага юм.

Тус ОНӨААТҮГ эрхэм зорилгоо “Түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг, төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж Хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм, шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хот төлөвлөлтийн суурь судалгааг хийх, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засгийн нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг үйл ажиллагааг эрхэлж байна.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор томилдог бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/17 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилсон байна.

ОНӨААТҮГ-ын удирдлагыг нийслэлийн Засаг дарга томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасантай нийцэж байна.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Зохиогчдын эрх болон түүнийг хамгаалах эрхийн тухай хууль, Газрын тухай хууль, Авто замын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль.

**Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ -ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

- Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах” А/52 дугаар тушаал.

ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Нийслэлийн дотоод аудитын албанаас тус ОНӨААТҮГ-ын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудиторын хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэх захирлын 2023 оны А/22 тоот тушаалаар баталсан ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,834,554.6 мянган төгрөгөөр буюу 64.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,806,480.10	751,477.70	(4,055,002.40)
Авлага	783,124.70	738,047.20	(45,077.50)
Бараа материал	57,758.20	94,812.50	37,054.30
Урьдчилж төлсөн зардал тооцоо	6,639.50	23,879.40	17,239.90
Үндсэн хөрөнгө	291,958.70	503,189.80	211,231.10
Нийт хөрөнгө	5,945,961.20	2,111,406.60	(3,834,554.60)
Өр төлбөр	4,123,792.30	208,221.60	(3,915,570.70)
Засгийн газрын хувь оролцоо	1,822,168.90	1,903,185.00	81,016.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,945,961.20	2,111,406.60	(3,834,554.60)

/мянган төгрөгөөр/

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 751,477.7 мянган төгрөг болж 4,055,002.4 мянган төгрөгөөр буурахад тайлант онд 3,498,878.4 мянган төгрөгийн гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгосон нь голлох нөлөө үзүүлсэн байна.
- Авлага дансны үлдэгдэл 738,047.2 мянган төгрөг болж 45,077.5 мянган төгрөгөөр буурсан нь зураг төсөв боловсруулах ажлын барьцааны авлага 46,355.0 мянган төгрөгөөр, зургийн ажлын тендерийн баталгаа, гүйцэтгэлийн барьцаа 110,717.1 мянган төгрөгөөр, зураг төсөв боловсруулах ажлын үлдэгдэл 39,650.4 мянган төгрөгөөр, ажилчдаас авах авлага 87.6 мянган төгрөгөөр, бусад авлага 5,640.1 мянган төгрөгөөр нийт 202,450.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оны авлагаас 247,527.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 94,812.5 мянган төгрөг болж 37,054.3 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын 60 жилийн ойн арга хэмжээнд зориулан бэлтгэсэн бараа материалын үлдэгдэл 28,205.4 мянган төгрөгтэй холбоотой байна. Энэ нь бараа материалын үлдэгдлийн өсөлтийн 76.1 хувийг эзэлж байна.
- Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэл 23,879.4 мянган төгрөг болж 17,239.9 төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч, 4 харилцагчид бараа материал, үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд зориулан 2024 оны 12-р сарын 27,31-ний өдрүүдэд 23,879.4 мянган төгрөгийн урьдчилгааг олгосонтой холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 503,189.8 мянган төгрөг болж 211,231.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 3,163.1 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 114,992.1 мянган төгрөгөөр тавилга эд хошгил, 205,167.5 мянган төгрөгөөр компьютер дагалдах хэрэгсэл, 11,286.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгө нийт 334,608.7 мянган төгрөгийн хөрөнгө тус тус худалдан авч, 4,572.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 4,314.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж данснаас хассан, 123,120.0 мянган төгрөгийн элэгдлийг тайлант онд байгуулсантай холбоотой байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 208,221.6 мянган төгрөг болж 3,915,570.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 3,498,878.4 мянган төгрөгийн гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийг олгосон, 572,727.2 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогыг тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрсөн, 23,800.0 мянган төгрөгийн гэрээт ажил цуцлагдсан, 178,538.8 мянган төгрөгийн өр үүссэн, татварын өглөг 1,296.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.
- Эздийн өмчийн дүн 1,897,544.9 мянган төгрөгт хүрч 75,376.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүн 321,056.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оны үр дүн рүү залруулсан НӨАТ-ын авлага 115,047.7 мянган төгрөг, НӨХГ-т төвлөрүүлсэн ногдол ашиг 124,992.8 мянган төгрөгөөр тус тус буурах өөрчлөлт орсонтой холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/755 дугаар захирамжаар 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 4,586,710.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,445,398.2 мянган төгрөгөөр, 141,312.4 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 353,953.4 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 6,264,389.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 5,907,660.0 мянган төгрөгийн зардал гарган, 356,729.6 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,264,389.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1,677,678.9 мянган төгрөг буюу 36.6 хувиар давсан нь нийслэлийн засаг даргын захирамжаар гүйцэтгэсэн нэмэлт ажилтай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 5,907,660.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,462,261.8 мянган төгрөг буюу 32.9 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь дээрх захирамжаар гүйцэтгэсэн ажлын холбогдох зардал болон ажлын байрыг нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой засварын зардал гарсан, ажилчдын цалинг нэмсэн зэрэгтэй холбоотой байна.

Тайлант оны татварын өмнөх ашиг 356,729.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 215,417.2 мянган төгрөгөөр давсан байна.

Тайлант онд 124,992.8 мянган төгрөгийг НӨХГ-т ногдол ашгийн төлбөрт төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн газрын үйл ажиллагааг сайжруулах, худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж, татварын цахим системийн баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх, өндөр насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, захирал П.Наранцэцэг нар анхан шатны хяналтыг, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ 2024 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/75 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 12,505,455.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 187,581.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, тайлант оны зардлын дүн материаллаг хэмжээгээр буюу 6,598,463.1 мянган төгрөгөөр буурсан тул 2024 оны жилийн эцсийн зардлын 5,906,992.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 88,604.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж бичиг хэргийн зардлыг 10,888.9 мянга, тээвэр шатахууны зардлыг 95,157.8 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 1,515.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 85,443.8 мянган төгрөгийн, зарлагын 656,206.1 мянган төгрөгийн, нийт 662,094.4 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Тайлант онд 155,615.6 мянган төгрөгийн худалдан авалтыг 3 харилцагчаас шууд гэрээгээр гүйцэтгэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”-02 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2.Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд 4-5 жилийн насжилттай 12 харилцагчаас авах 241,845.5 мянган төгрөгийн авлага, 11 жилийн насжилттай 43,827.0 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байгааг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өндөр насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй болон өр авлагыг барагдуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн 1,765,902.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага 3 зөвлөмж хүргүүлэх саналыг асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан.

Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, хэрэгжилт дутуу 2 зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	7,021,229.1	-	-	-
Зөвлөмж	2	186,761.7	-	-	-
Нийт дүн	3	7,207,990.8	-	-	-

Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв байршуулж, хэрэглэгчдийг ил тод мэдээллээр хангаж байх, худалдан авалтын и баримтыг тухай бүр шивж байх зөвлөмж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг тус тус хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь чиг үүргийнхээ дагуу улсын захиалгат ажлуудыг гүйцэтгэж, улс, орон нутгийн төсвөөс захиалгат ажлын санхүүжилт авч байгаагаас гадна, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/286 тоот захирамжаар үйл ажиллагааны